| 9   | Тайлант үеийн үр дүн                     | 0                                  | 0                        | 102,421,619.09       | 102,421,619.09                                |
| 10  | 2021 оны 12-р сарын 31-нээрх<br>үлдэгдэл | 254,549,065.00                     | 161,217,895.36           | 156,561,819.05       | 572,328,779.41                                |
| 11  | 2022 оны 1-р сарын 1-нээрх<br>үлдэгдэл   | 254,549,065.00                     | 161,217,895.36           | 156,561,819.05       | 572,328,779.41                                |
| 13  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл               | 254,549,065.00                     | 161,217,895.36           | 156,561,819.05       | 572,328,779.41                                |
| 19  | Тайлант үеийн үр дүн                     | 0                                  | 0                        | 30,642,257.11        | 30,642,257.11                                 |
| 20  | 2022 оны 12-р сарын 31-нээрх<br>үлдэгдэл | 254,549,065.00                     | 161,217,895.36           | 187,204,076.16       | 602,971,036.52                                |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
/төгрөгөөр/

| Код         | Үзүүлэлт                                                             | Төлөвлөгөө              | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|-------------|----------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------------|
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | <b>1,096,143,500.00</b> | <b>1,004,093,542.20</b>     |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                 | <b>1,096,143,500.00</b> | <b>1,004,093,542.20</b>     |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>1,093,883,500.00</b> | <b>1,001,943,542.20</b>     |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | <b>852,724,400.00</b>   | <b>788,348,618.00</b>       |
| 210101      | Үндсэн цалин                                                         | 471,036,000.00          | 472,680,772.00              |
| 210102      | Нэмэгдэл                                                             | 318,443,400.00          | 247,332,218.00              |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                                | 40,492,000.00           | 33,845,000.00               |
| 210104      | Урамшуулал                                                           | 22,753,000.00           | 34,490,628.00               |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>106,590,500.00</b>   | <b>96,460,975.00</b>        |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                   | 73,860,500.00           | 66,013,341.93               |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                   | 8,182,500.00            | 7,766,276.18                |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                    | 6,546,000.00            | 6,102,141.01                |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                 | 1,636,500.00            | 1,507,201.02                |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                | 16,365,000.00           | 15,072,014.86               |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>36,030,000.00</b>    | <b>35,348,823.00</b>        |
| 210301      | Гэрэл, цахилгаан                                                     | 3,717,200.00            | 3,683,894.00                |
| 210302      | Түлш, халаалт                                                        | 27,792,700.00           | 27,764,825.00               |
| 210303      | Цэвэр, бохир ус                                                      | 4,520,100.00            | 3,900,104.00                |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>32,631,400.00</b>    | <b>32,592,467.20</b>        |
| 210401      | Бичиг хэрэг                                                          | 10,452,400.00           | 10,413,470.00               |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                     | 12,056,000.00           | 12,056,000.20               |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 5,682,000.00            | 5,681,997.00                |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн                             | 337,000.00              | 337,000.00                  |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 4,104,000.00            | 4,104,000.00                |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                              | <b>1,500,000.00</b>     | <b>1,493,600.00</b>         |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                          | 1,500,000.00            | 1,493,600.00                |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>27,934,000.00</b>    | <b>27,907,190.00</b>        |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                              | 10,000,000.00           | 9,992,000.00                |
| 210602      | Тавилга                                                              | 10,000,000.00           | 9,989,500.00                |
| 210604      | Урсгал засвар                                                        | 7,934,000.00            | 7,925,690.00                |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                        | <b>5,800,000.00</b>     | <b>5,362,000.00</b>         |
| 210702      | Дотоод албан томилолт                                                | 5,800,000.00            | 5,362,000.00                |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний</b>                      | <b>19,163,100.00</b>    | <b>8,243,069.00</b>         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,290,000.00           | 7,369,969.00                |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 432,000.00              | 432,000.00                  |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                           | 235,000.00              | 235,000.00                  |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                        | 66,000.00               | 66,000.00                   |
| 210807      | Газрын төлбөр                                                        | 140,100.00              | 140,100.00                  |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>11,510,100.00</b>    | <b>6,186,800.00</b>         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 6,510,100.00            | 6,186,800.00                |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 5,000,000.00            | 0                           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                              | <b>2,260,000.00</b>     | <b>2,150,000.00</b>         |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                        | <b>2,260,000.00</b>     | <b>2,150,000.00</b>         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 2,260,000.00            | 2,150,000.00                |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>1,096,143,500.00</b> | <b>1,004,093,542.20</b>     |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>1,096,143,500.00</b> | <b>1,004,093,542.20</b>     |
| 310001      | Улсын төсвөөс санхүүжих                                              | 1,096,143,500.00        | 1,004,093,542.20            |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Прокурорын газар нь эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулан, хүний эрх, эрх чөлөө, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээн, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцдог чиг үүрэг бүхий Улсын ерөнхий Прокурорын газарт тайлангаа нэгтгэдэг Хууль зүйн яамны харьяа байгууллага юм.

Тус газар нь олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулах, үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлыг хангаж, хяналтын ажлын үр нөлөөг сайжруулж, цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих, Прокурор, ажилтны ажиллах, суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, хүрээг тэлэх, хорих ангиудын ажиллагаанд байнгын хяналт тавих, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Төв аймгийн Прокурорын газар нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 119 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 100 %-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Прокурорын газар нь нэгдмэл төвлөрсөн удирдлагатай ба тайлант онд аймгийн ерөнхий прокурор 1, орлогч прокурор 1, ахлах прокурор 3, хяналтын прокурор 11, Тамгын хэлтсийн дарга 1, прокурорын туслах ажилтан 4, үйлчилгээний ажилтан 11 бүгд 32 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Прокурорын байгууллага нь 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэс суурь болгон боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, гадаад, дотоод орчны хурдацтай өөрчлөлт нь прокурорын байгууллагын үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах хэрэгцээг бий болгож байна. Мөн гадаад, дотоод болон олон улсын байгууллагатай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна.

Төв аймгийн Прокурорын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Прокурорын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотойгоор Улсын ерөнхий Прокурорын газар нь хөдөлмөрийн

дотоод журам болон холбогдох баримт бичигт орсон өөрчлөлтийг нэгжүүдэд ирүүлэн мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Улсын ерөнхий Прокурорын газрын Дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын хэлтсээс дотоод аудитын үйл ажиллагааг удирдан явуулдаг, дотоод аудитор 1 орон тоотой ажилладаг ба батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу салбар нэгжид хяналт шалгалтыг явуулж үр дүнг бүх нэгжүүдэд мэдээлэн цахимаар ярилцлага хийж удирдлага зохион байгуулалтаар ханган ажилладаг байна.

УЕПГ-ын дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын хэлтсээс 2022 онд дотоод аудитын шалгалтыг хийж 2021, 2022 оны 4 дүгээр сар хүртэлх баримтыг шалгасан ба алдаа зөрчил илрээгүй байна.

Аймгийн Прокурорын газар нь 2022 оны 2 дугаар улирлын байдлаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажлын хүрээнд сумдад шалган туслах ажлыг зохион байгуулж, сумын хэсгийн төлөөлөгч, иргэдэд гарын авлага тараах материалыг өгч хууль эрх зүйн мэдлэгийг хүргэж ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Прокурорын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Улсын ерөнхий Прокурорын 2021 оны 12 дугаар сарын 16-ны А/179 дугаар тушаалаар батлагдсан шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Прокурорын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,642.3 мянган төгрөгөөр буюу 5,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт       | Эхний<br>үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |          |
|----------------|-------------------|--------------------|----------|
|                |                   | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б              | 1                 | 2                  | 3=2-1    |
| Мөнгөн хөрөнгө | 12,575.6          | 11,575.6           | -1,000.0 |
| Авлага         | 0                 | 0                  |          |

|                                              |                  |                  |                 |
|----------------------------------------------|------------------|------------------|-----------------|
| Бараа материал                               | 21,473.8         | 21,168.3         | -305.5          |
| Үндсэн хөрөнгө                               | 550,854.9        | 581,802.7        | 30,947.8        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>584,904.3</b> | <b>614,546.6</b> | <b>29,642.3</b> |
| Өр төлбөр                                    | 12,575.6         | 11,575.6         | -1000.0         |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 572,328.7        | 602,971.0        | 30,642.3        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>584,904.3</b> | <b>614,546.6</b> | <b>29,642.3</b> |

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн дансанд орлого зарлагын хөдөлгөөн хийгдсэн болон хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан өмнөх оны үзүүлэлтээс 30,947.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 602,971.0 мянган төгрөг болж 30,642.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,071,253.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого байхгүй, нийт зарлагыг 1,071,253.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Прокурорын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 76,365.6 мянган төгрөгөөр бууруулан УЕПГ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/190 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар 2022 оны урсгал зардлын төсвийг 996,887.7 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Тайлант хугацаанд 2022 оны 5 дугаар сарын 19-нд 1,047,890.2 мянган төгрөгөөр, 7 дугаар сарын 04-нд 1,059,252.1 мянган төгрөгөөр, 10 дугаар сарын 06-нд 1,084,653.5 мянган төгрөгөөр, 12 дугаар сарын 07-ний өдрийн А/129 тоот тушаалаар 1,096,143.5 мянган төгрөгөөр тус тус тодотгон 4 удаа өөрчлөлт хийгдсэн байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл тухайн байгууллагын төсвийн төсөлд хүргүүлсэн саналд үндэслэдэггүй баталдгаас шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 996,887.7 мянган төгрөгийг 99,255.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 4 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг прокурорын хяналт хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,096,143.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 92,049,9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,004,093,6 мянган төгрөг буюу 91,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 92,049,9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ |         |
|-----|-----------------------|-------------|-----------|--------------------|---------|
|     |                       |             |           | Зөрүү              | Биелэлт |
|     | 70703/80101           | 1,085,883.5 | 994,573.6 | 91,309.9           | 91,6    |
|     | 70703/82315           | 8,000.0     | 7,369.9   | 630.1              | 92,1    |

|  |             |         |         |       |      |
|--|-------------|---------|---------|-------|------|
|  | 70703/80802 | 2,260.0 | 2,150.0 | 110.0 | 95,1 |
|--|-------------|---------|---------|-------|------|

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Прокурорын газар нь 2022 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт нэг хөтөлбөрийн гурван арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

| /мянган төгрөгөөр/ |          |                       |                   |                  |                 |             |
|--------------------|----------|-----------------------|-------------------|------------------|-----------------|-------------|
| №                  | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа      | Хүрэх үр дүн      | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан  |
| 1                  | 70703    | 2022.01.01-2022.12.31 | Прокурорын хяналт | Хөтөлбөр 100 %   | 1,096,143.5     | 1,004,093.5 |

Төв аймгийн Прокурорын газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 92,049.9 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/142 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Улсын ерөнхий Прокурорын газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Прокурорын газрын батлагдсан 2022 оны нийт зарлага 1,084.653.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 16,269.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,202.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг Төв аймгийн Прокурорын газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/220 дугаар албан бичгээр ирүүлсэн. Үүнд: Тус байгууллагын 2022 оны төсвөөс байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засвар, дотоод албан томилолт, байцаан шийтгэх бараа үйлчилгээний зардал, цалингийн зардлаас бусад бүх зардлыг 15-20 хувиар бууруулан баталсан ба төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 92,049.9 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Энэ хуулийн хүрээнд Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 64,375.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,129.6 мянган төгрөгөөр хэмнэсэн ба ажиллагсдад 3 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал олгоогүйгээс 33,662.4 мянган төгрөгийн бодит хэмнэлтийг бий болгожээ.

Мөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд прокурорын ажилчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд зориулан 10,290.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд хичээл үйлдвэрлэлийн дадлага, сургалт, хурал, зөвлөгөөн хийхэд зориулсан 5,000.0 мянган төгрөг бүгд 15,290.0 мянган төгрөгийг тэвчиж болох зардал хэмээн зарцуулаагүй хэмнэж ажилласан байна.



#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Прокурорын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 орлогын, 3 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Прокурорын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг Прокурорын газрын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/183 дугаар албан бичгээр ирүүлсэн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |          | Биелэлт |          |      |
|-----------------|------------------------|----------|---------|----------|------|
|                 | Тоо                    | Дүн      | Тоо     | Дүн      | Хувь |
| Акт             |                        |          |         |          |      |
| Албан шаардлага |                        |          |         |          |      |
| Зөвлөмж         | 2                      | 73,200.0 | 2       | 73,200.0 | 100  |
| Нийт дүн        | 2                      | 73,200.0 | 2       | 73,200.0 | 100  |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Прокурорын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар залруулсан алдаа байхгүй ба төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.